

Ерөнхий боловсролын салбарын бодлогын зохицуулалт, сургалтын байгууллагын хөгжил, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Аръяа Цолмон

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн , дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Ерөнхий боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах богино хугацааны төлөвлөгөө, арга хэмжээ боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах							
1	Ерөнхий боловсролын сургуулийн суудлын тоог үе шаттай нэмэгдүүлж, сургуулиудад бүтцийн дахин төлөвлөлт хийнэ.	Сургуулийн бүтцийг дахин төлөвлөх санал	-	Сургуулийн бүтцийн дахин төлөвлөлт хийх тооцоолол хийсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулийн бүтцийн дахин төлөвлөлтийн онол, арга зүйн талаар олон улсын судалгааны материалтай танилцаж, аймаг, суманд байршилтай сургуулийн хэмжээний өнөөгийн байдлын тооцоолол хийлээ. Сургуулийн хэмжээ олон талаар сургалтын үр дүнд нөлөөлдөг бөгөөд суралцагчийн тоо нэмэгдэх тусам тодорхой эдийн засгийн зардал буурч, сургуулийн хэмжээ хэт томроход захиргааны бүтэц төвөгтэй болж үр ашиг буурдаг гэж үздэг. Иймд бага сургуулийг 300-500 суралцагчтай, бусад түвшинд, нэн ялангуяа ахлах сургуулийг 600-900 суралцагчтай байх нь тохиромжтой хэмээн үзсэн үр дүнг олон улсын судалгаанаас харж болохоор байна. ЭЗХАХБ-ын орнуудад 300 болон түүнээс цөөн суралцагчтай бол “жижиг сургууль”	4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					гэж үздэг юм байна. Харин дунд сургууль 660 орчим, ахлах сургууль 920 орчим суралцагчтай бол “дундаж хэмжээтэй” сургууль гэж үзжээ. Мөн боловсролын үр дүнд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаанд сургуулийн хэмжээ сургалтын үр дүнд эерэгээр нөлөөлөх боломжит хэмжээг 680-960 гэж тогтоосон судалгаа бий. Манай улсын 339 сум, дүүргийн хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын 705 сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 76.5 хувь нь орон нутагт байна. Аймаг, суманд байршилтай нийт сургуулийн 261 буюу 48.4 хувь нь 500-аас доош суралцагчтай, 133 буюу 24.7 хувь нь 500-897 суралцагчтай, 56 буюу 10.4 хувь нь 904-996 суралцагчтай, 40 буюу 7.4 хувь нь 1200-1597 суралцагчтай, 49 буюу 9 хувь нь 1600-5000 суралцагчтай байна. Манай улсын 330 сумын 72.1 хувь (238)-д нь 1-12 дугаар ангитай бүрэн дунд сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 217 буюу 91.1 хувь нь суманд байна. Иймээс суманд байршилтай бүрэн дунд сургуулийн бүтцийг (i) хүн амын тооны өсөлт, (ii) ээлжийн коэффициент, (iii) бүлэг дүүргэлт; (iv) дотоод үр ашиг; (v) сургалтын чанар, (vi) багшийн чанар, (vii) сургалтын орчин, нөөцийн хүртээмж, (viii) төсөв түүний үр ашиг гэсэн үзүүлэлтээр нэмж тооцох шаардлага үүссэн. Хавсралт: 1 файл		
2	Төрөлжсөн ахлах сургуулийн	Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэл	-	Төрөлжсөн ахлах сургуулийг	Боловсролын сайдын 2025 оны А/188 дугаар тушаалаар “Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэл”-ийг	2-р сар, 3-р сар, 4-р сар,	Өөрийн үнэлгээ:

	талаар баримтлах чиглэлийг батлуулж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ.			хөгжүүлэх бодлогын чиглэлийг тодорхойлсон байна.	батлууллаа. Төрөлжсөн ахлах сургууль нь 10-12 дугаар ангитай байх бөгөөд суралцагчдад бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхийн зэрэгцээ тэднийг дараагийн түвшний боловсрол болон ажил мэргэжлээ сонгоход бэлтгэх, мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Ахлах сургууль нь технологи, хөдөө аж ахуй, эрүүл мэнд-сувилахуй, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, байгалийн ухаан, математик, нийгэм-хүмүүнлэг, соёл урлаг, спортын чиглэлээр төрөлжинө. Харин мэргэжлийн эрх олгох сургалтыг технологи, хөдөө аж ахуй, эрүүл мэнд-сувилахуй, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ гэсэн чиглэлээс сонгон зохион байгуулж, төгсөгчдөд чадамжийн гэрчилгээ олгох бодлого баримтлахаар заасан. Төрөлжсөн ахлах сургууль нь их сургууль, коллежитой хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, эсхүл их сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургуулийн мэргэжлийн суурь хичээлийг сонгон судлах хичээлээр суралцагч судалж болох эрхийг нээж өгсөн. Хавсралт: 1 файл	5-р сар	100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3	"Сургуулийн соёл, суралцагчийн төлөвшил" арга хэмжээг хэрэгжүүлэх удирдамжийн төсөл боловсруулах	Удирдамж/хэрэгжилтийн хувь	-	Удирдамжийн төслийг боловсруулж, танилцуулсан байна.	"Сургуулийн соёл-суралцагчийн төлөвшлийг дэмжих үйл ажиллагааны удирдамж"-ийг Боловсролын сайдын 2025 оны А/224 дүгээр тушаалаар батлууллаа. Энэхүү удирдамж нь сургуулийн эерэг соёл төлөвшүүлэхэд чиглэсэн бөгөөд энэ хүрээнд талуудын хамтын оролцоо, зөв хандлага, ёс зүй, харилцан хүндлэл, итгэлцэл, дэмжлэгт суурилан сургуулийн хамт олны үнэт зүйл, эерэг дадал,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн

					харилцаа, хандлагыг дэмжих, суралцагчийн төлөвшилд талуудын оролцоог нэмэгдүүлэх 4 чиглэлд хамаарах үйл ажиллагааг тус тус тодорхойлсон. Удирдамжийг төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиуд өөрийн онцлогт нийцүүлэн 2025-2026 оны хичээлийн жилээс 3 үе шаттай хэрэгжүүлнэ. Мөн удирдамжид заасан үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх тогтмол ажлын төлөвлөгөөний нэгэн хувилбарыг боловсруулсан болно. Хавсралт: 2 файл		даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1.2. Ерөнхий боловсролын салбарын нийтлэг харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлага, зохицуулалтаар хангах							
4	Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам", "Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам"-ыг	Журам	-	Нэр бүхий 2 журмын төслийг боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлуулан хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн байна.	“Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам”, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ыг тус тус Боловсролын сайдын 2025 оны А/25 дугаар тушаалаар батлууллаа. Энэхүү журмаар багшийг ажилласан жилээс үл хамаарч тэдний чадамжид суурилан ажил үүргээ гүйцэтгэхэд нь шууд хэрэглээ болох агуулгад чиглүүлэн ажлын байранд нь болон орон нутагт хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, мөн анхны жилдээ ажиллаж байгаа багшийг багшлах ажилд дагалдуулан сургах, зөвлөн туслах үйл ажиллагаанд хамруулахаар зохицуулсан. Харин мэргэжил дээшлүүлэх сургалт нь үндсэн болон төрөлжсөн гэсэн 2 төрөлтэй, үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулах, багш 5 жил тутамд	1-р сар, 2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

	батлуулна.				багшийн чадамжийн стандартын түвшин ахиулах үндсэн сургалтад нийт 4 хүртэлх удаа, удирдах ажилтан чадамжийн түвшин ахиулах үндсэн сургалтад тухайн албан тушаалд томилогдон ажилласан 2 дахь жилээс эхлэн 5 жил тутамд нийт 3 хүртэлх удаа тус тус хамрагдахаар зохицуулсан. Сургалт шатлан гүнзгийрсэн агуулгатай байх бөгөөд төрөлжсөн сургалтыг үндэсний түвшинд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвтэй, орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн боловсролын газар багшийн хөгжлийг дэмжих бүсийн төвтэй хамтран зохион байгуулна. Нэр бүхий 2 журмыг танилцуулах сургалтыг Боловсролын ерөнхий газар, аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга, мэргэжилтэн болон Дундговь, Өмнөговь аймгийн цэцэрлэг, сургуулийн захирал, эрхлэгч, сургалтын менежер, арга зүйч нарт тус тус зохион байгууллаа. Хавсралт: 1 файл		
5	Сургуулийн нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулна .	Шалгуур үзүүлэлт	-	Засгийн газрын 2013 оны 229 дүгээр тогтоолоор баталсан "Сургуулийн нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг, нэмэгдэл хөлс олгох журам"-	Сургуулийн нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулж, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны төлөөлөл (2025.03.14) болон нийгмийн ажилтан бэлтгэдэг их, дээд сургуулийн мэргэжлийн тэнхимийн багш нар (2025.04.28, 2025.05.27)-аар тус тус 3 удаа хэлэлцүүлж, санал аваад байна. Шалгуур үзүүлэлтийн төсөл нь хүүхэд хамгааллын ажил, хүүхэд хамгааллын	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа

				ыг хүчингүй болгох эсэх талаар санал боловсруулсан байна.	хөтөлбөр, үйлчилгээний загвар, судалгаа, шинжилгээ, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг, хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоо, мэргэжлийн хөгжил гэсэн агуулгыг хамарсан. Мэргэшлийн ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг тус бүрд 10 шалгуур үзүүлэлт байхаар тусгасан. Шалгуур үзүүлэлт бүр нь тодорхой, хэмжихүйц байдлыг хангаж, нотлох баримтаар баталгаажих боломжтой байх, шатлал ахих тусам шаардлагатай мэдлэг, ур чадвар, арга зүйн манлайлал гүнзгийрч байгаа шаталсан бүтэцтэй байхаар томьёолсон. Харин Засгийн газрын 2013 оны 229 дүгээр тогтоолоор баталсан “Сургуулийн нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг, нэмэгдэл хөлс олгох журам”-ыг холбогдох хуульд нийцүүлэн хүчингүй болгох тухай Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулгын хамт бэлтгээд байна. Хавсралт: 2 файл		гүйцэтгэсэн байдал: 100%
6	Дотуур байрны багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагыг боловсруулж батлуулна.	Нийлэг шаардлага	-	Албан тушаалд тавигдах нийтлэг шаардлагын төслийг боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлуулсан байна.	Боловсролын сайдын 2025 оны А/106 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага”-ыг батлууллаа. Дотуур байрны багш нь бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй, багш, эсхүл нийгмийн ажил, сэтгэл судлалын мэргэжилтэй байх, багшаас бусад мэргэжилтэй иргэн багш бэлтгэх хувилбарт сургалтад хамрагдаж төгссөн байхаар заасан. Багшийн мэдлэг, ур чадварт тавих шаардлагыг (i) ажил үүрэг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, (ii) ажил үүрэг гүйцэтгэхэд шаардагдах чадвар гэж 2 ангилан авч үзсэн. Ажил үүрэг гүйцэтгэхэд шаардагдах чадвар нь (i) хүүхдийн	2-р сар, 3-р сар, 4-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн

					хөгжлийг дэмжих, (ii) хүүхдэд эерэг зан үйл төлөвшүүлэх, (iii) хүүхдийн эрх, хамгаалал, (iv) хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн. Мөн дотуур байрны багшийн ажил үүргийг тодорхой болгосон. Ингэснээр дотуур байрны багш хаана ажиллаж амьдарч байгаагаас үл хамааран ижил ажил үүрэг гүйцэтгэх (сургууль бүр дотуур байрны багшийн ажил үүргийг харилцан адилгүй тогтоодог байсан) төдийгүй ажил олгогч тал албан тушаалын тодорхойлолт боловсруулахад бодит дэмжлэг болно. Хавсралт: 1 файл		байдал: 100%
1.3. Ерөнхий боловсролын салбарын урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах							
7	Ерөнхий боловсролын салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн ил тод байдал	-	Ерөнхий боловсролын салбарт хамаарах эрх зүйн актын талаарх мэдээллийг хуульд заасны дагуу холбогдох цахим хуудаснаа байршуулсан байна.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний 2025 оны А/25, А/106, А/188 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам”, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”, “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага”, “Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэл”-ийг яамны цахим хуудасны "Баримталж буй бодлого, чиглэл" цэс (https://moe.gov.mn/posts?category_id=11416 линкээс үзэх боломжтой)-нээ	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					байршууллаа.		
3.1. Ерөнхий боловсролын салбарын урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах							
8	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах	Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах аргачлалд заасан шаардлагыг бүрэн хангасан байх	-	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг тогтоосон хугацаанд батлуулж, хэрэгжилтийг тайлагнасан байна.	Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар баталсан аргачлалыг тус тус баримтлан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, нэгжийн даргаар батлуулан түүний хэрэгжилтийг хангаж ажиллалаа.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
9	Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнах	Тайлагналын баримт бичигт тавигдах шаардлага хангасан, үнэн, зөв, дүгнэлттэй, хугацаандаа гарсан байх	-	Бодлогын баримт бичигт тусгагдсан эрхлэх асуудалд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг чанартай тайлагнасан байна.	Тайлангийн хугацаанд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон Хууль тогтоомжийн хэрэгжилтийн эрхлэх асуудалд хамаарах холбогдох заалтын хэрэгжилтийг тус тус тайлагнаж ажиллалаа.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн

							хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
10	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэх	Ирсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлт	-	Албан бичиг, өргөдөл гомдлыг хуульд заасан хугацаанд барагдуулсан байна.	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 13 өргөдөл, гомдол, 19 албан бичиг (2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар) хуулийн хугацаанд бүрэн барагдуулсны гадна нийт 14 албан бичгийн төсөл боловсруулж, холбогдох удирдах ажилтнаар хянуулан баталгаажуулан хүргүүлсэн байна. Мөн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу эрхлэх асуудлаар 1 боть/234 хуудас бүхий/ материалыг хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивд 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр хүлээлгэн өгсөн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
11	Ерөнхий боловсролын салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн ил тод байдал	-	Ерөнхий боловсролын салбарт хамаарах эрх зүйн актын талаарх мэдээллийг хуульд заасны дагуу холбогдох цахим хуудаснаа байршуулсан	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний 2025 оны А/25, А/106, А/188 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам”, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”, “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага”, “Төрөлжсөн ахлах сургуулийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн

				байна.	талаар баримтлах чиглэл"-ийг тус тус яамны цахим хуудасны "Баримталж буй бодлого, чиглэл" цэс (https://moe.gov.mn/posts?category_id=11416 линкээс үзэх боломжтой)-нээ байршууллаа.		хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--------	--	--	--------------------------------------

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Ерөнхий боловсролын салбарын чиглэлээр гарч байгаа олон улсын судалгааны ажил, өгүүллэг уншиж гадаад хэлний	UNESCO, OECD зэрэг олон улсын байгууллагын цахим сайтаас боловсролын хөгжлийн чиг хандлагын талаар гарч байгаа	-	Ерөнхий боловсролын салбарын чиглэлээр англи хэл дээр гарч байгаа олон улсын судалгааны ажил, өгүүллэгийг уншиж	Тайлангийн хугацаанд ЮНЕСКО, Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага/OECD/ байгууллагын цахим хуудаснаа байршсан Future-focused mathematics curricula http://www.oecd.org/en/publications/future-focused-mathematics-curricula_18036510-en.html , Policies for the digital transformation of school education http://www.oecd.org/en/publications/policies-for-the-digital-transformation-of-school-education_464dab4d-en.html , Education and nutrition LEARN TO EAT WELL/Global education monitoring report, 2025 http://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000392932/PDF/392932eng.pdf.multi зэрэг судалгааны тайлан, өгүүлэл, сургалтын материалтай тус тус танилцан, англи хэлээр уншиж ойлгох чадвараа сайжруулж, мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлэв. Мөн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

	мэдлэгээ дээшлүүлэх	бодлогын зөвлөмж, гарын авлагыг уншиж судлах		танилцана	Outline of Plan for Building China into a leading Country in Education (2024-2035), White Paper on China's Smart Education (May, 2025), Ministry of Education, People's Republic of China гарын авлагыг судалж байна.	сар	
2	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг судлах	Эрхлэх асуудалд хамаарах шинээр батлагдсан хууль тогтоомжийг судлах, сан үүсгэх	-	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг судалж, эрхлэх асуудлаар бодлогын баримт бичиг боловсруулахад уялдуулж, нийцлийг хангана.	Засгийн газрын 2025 оны 02, 43, 158, 215, 218 дугаар тогтоолоор батлагдсан “Бүсийн зөвлөлийн ажиллах журам”, “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарлах, “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” болон “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар албан даалгавар, “Хүйтний улиралд ажлын цагийн зохицуулалт хийх” Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тэмдэглэл зэрэг захиргааны хэм хэмжээний 7 актыг тус тус судлан эрхлэх асуудлаар бодлогын баримт бичиг боловсруулахад ашиглаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ерөнхий боловсролын салбарын бодлогын зохицуулалт, сургалтын байгууллагын хөгжил, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Аръяа Цолмон /...../ Огноо: